

## Цөмийн хаягдлыг Монголын нутагт агуулбал мөнгө өгнө гэж хэмжээг нь хүртэл хэлээд байна

**Б.ДОЛЗОДМАА**

**Эх сурвалж: Өдрийн Сонин**

<http://www.dailynews.mn/publish/?vid=19095>

*Япон, Америкийн Засгийн газар манай улсын дээд албан тушаалын хүмүүстэй нууц хэлэлцээр хийж Монголын газар нутаг дор олон улсын цөмийн хаягдлын агуулах барих төсөл хийж байсан талаарх мэдээлэл дуулиан тарьж байна. Гадаад харилцааны яамнаас уржигдар яаралтай хэвлэлийн бага хурал зарлаж энэхүү мэдээллийг үгүйсгэсэн. Манай улсад цөмийн хаягдлын агуулах барих нууц хэлэлцээрийн тухай Монголд ирж сурвалжлага хийсэн Японы “Майничи” сонины Лондон дахь тусгай сурвалжлагч Айкава Харүюкитай холбогдлоо. Тэрбээр өнгөрсөн дөрөвдүгээр сард Монголд ирээд буцсан бөгөөд Лондонгоос түүнтэй интернэтээр шууд холбогдож Н.Энхжаргал орчуулагчийн тусламжтайгаар ярилцсанаа хүргэе.*

**-Та юуны өмнө Монголд ирж сурвалжлага хийсэн талаар мэдээлэл хүргэхгүй юу?**

-АНУ, Япон улс атомын цахилгаан станцын талаар Монголд ярилцаж байгаа эсэхийг мэдэхээр би Монгол руу ирсэн. Америк, Япон, Монголын гурван талт хэлэлцээр гэдгийг сонсоод манай Япон улсад хамааралтай болохоор энэ талаар бичиж тэмдэглэх зорилгоор Монголыг зорьсон.

**-Монголд ирээд төрсөн сэтгэгдлээсээ хуваалцаач?**

-Монголд анх удаа очсон. Үнэхээр сайхан газар. Монгол хүмүүс эел-дэг дулаахан санагдсан. Японд болсон цунами газар хөдлөлтийн үед монголчууд сэтгэлээсээ тусалж цалингаасаа хан-дивлаж байсан нь үнэ-хээр сэтгэл хөдлөм гай-хал-тай санагдсан. Мон-гол-чуудад чин сэтгэлээ-сээ баярлалаа гэж хэл-мээр байна.

**-Та Монголд олон газраар явав уу. Аль аймагт очиж хаана, ямар байдлаар ажиллав?**

-Би “Майничи” сонин дээрээ бичигдсэнээс илүү мэдээллийг хэлж чадах-гүй нь. Энэ талаар хэлэх боломжгүй байна л даа.

**-Нууц гэж үү?**

-(Хариулт хэлсэнгүй инээгээд өнгөрөв)

**-Монгол Улсад цөмийн хаягдал агуулах барих тухай ямар гэрээ, хэлцэл хийгдсэн юм бол. Хэзээ, хаана, ямар уулзалт болж байсан зэрэг олон асуулт хөврөх нь. Энэ гэрээ хэлэлцээртэй холбоотой мэдээллийг Монголын уншигчидтай хуваалцахгүй юу?**

-Энэ асуудлын талаар зөвхөн ганц Монголд ч биш өөр улс оронд очиж ярилцлага авч яваа. Дарааллаар нь ярья л даа. Өнгөрсөн 2010 оны есдүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд АНУ-ын Эрчим хүчний яамны орлогч захирал Понэман Монголд айлчлалаар ирснээс эхлэлтэйгээр хэлэлцээр яригдаж эхэлсэн. Япон улс болохоор өнгөрсөн жилийн аравдугаар сараас эхлэн хэлэлцээрт нэгдэн орсон. АНУ, Япон, Монгол гурван улсын хооронд утсаар ярих ч юмуу эсвэл ямар нэгэн байдлаар энэ талаар гурвалсан яриа яригдах болсон гэдэг нь тодорхой.

**-Монголын талаас ямар түвшний албаны хүмүүс харилцаатай уулзалдаж байгаа юм бол?**

-Японоос Эдийн Засгийн худалдааны яам, Монголын талаас Гадаад харилцааны яам төлөөлсөн гэж бодож байна.

**-Ямар хэлэлцээр хийсэн талаар та тодорхой тайлбарлахгүй юу?**

-Монгол Улс ураны нөөцтэй. Мөн нефтьтэй. Атомын цахилгаан станц барих техник, технологи Монголд шууд алга байна. Монголын зүгээс атомын цахилгаан станц барих техник, технологийг хүсч байгаа. АНУ Монголд зөвлөмж байдлаар хандахдаа цөмийн түлш гаргах нь эдийн засгийн хувьд нэг их ашигтай биш. Яагаад гэвэл дэлхийн олон улс орон атомын цахилгаан станц, цөмийн түлш гаргаж байна. Гэхдээ бид нар та нарт цөмийн түлш хийхэд чинь тусалъя. Та нар эргээд бидэнд хариу тусал гэх байдлаар тус нэхсэн маягийн яриа явуулж байгаа юм билээ. АНУ-ын тулгамдсан асуудлын нэгд атомын цахилгаан станцад хэрэглэсэн цөмийн түлшний хаягдлыг эргээд хэрхэх вэ гэдэг яах аргагүй орно Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ, монголчуудыг туслахгүй юу гэх маягаар ярилцаж байна. Хэрэглэсэн цөмийн түлш яагаад дэлхий нийтэд тулгамдсан асуудал байгаа талаар хэлье гэж бодож байна. Дэлхийн олон улс оронд атомын цахилгаан станц бий. Шинээр нэмэгдэж хэд хэдэн улс орон ч цахилгаан станц барихаар төлөвлөсөн.

АНУ-ын зүгээс цөмийн зэвсэг үйлдвэрлэх, дахин боловс-руулах улс орон шинээр бий болгохоосоо илүүтэй атомын цахилгаан станцад хэрэглэсэн цөмийн түлшний хаягдлыг аюулгүй амар тайван газарт аваачихыг хүсч байна. Дэлхий нийтээр 1990 оноос хойш хорь гаруй жилийн турш цөмийн хаягдлыг хэрхэх вэ гэдгийг ярилцаж байгаа ч нэгдсэн тодорхой шийдвэрт хүрээгүй. 2005 оноос эхлэн Олон улсын Атомын цахилгаан станцын холбоо (IAEA)-ноос янз бүрийн таамаг санал дэвшүүлж, цөмийн хаягдлыг найдвартай хадгалах олон улсын төвийг Ази, Европт нэг нэгийг байгуулъя гэх мэтчилэн ярилцсаар л байна.

Энэ асуудлыг олон нийтийн дунд хамгийн идэвхтэй ярьж байгаа нь АНУ. Ер нь цөмийн зэвсгийн хаягдлыг хамгийн найдвартай хадгалах арга нь газрын гүнд 100 мянган жилийн хугацаанд найдвартайгаар булах гэж үздэг. Үүнийг гүний устай газар булж болдоггүй. Үнэндээ дэлхийн улс орноос хайгаад үзэхээр газрын гүний усгүй улс орон гэж бараг байхгүй. Монгол, Казахстан, Австрали, Аргентин зэрэг улс орныг говь элсэрхэг газар нутагтай учир цөмийн зэвсгийн хаягдлыг булбал хамгийн найдвартай гэж яригдах нь бий. Ийм цаг үед Монгол Улс уранаас цөмийн түлш гаргаж Арабын нэгдсэн Эмират улс (UAE)-д нийлүүлье гэж яриад байгаа юм билээ. Энэ жилийн нэгдүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайд тус улс руу албан айлчлалаар явсан.

Айлчлалын үеэр Монголд хийх цөмийн түлшийг худалдаж авахгүй юм уу гэж бизнесийн санал тавьсан юм байна. Ингэхдээ цөмийн түлшийг эхлээд зараад дараа нь хэрэглээд дууссан хойно хаягдлыг нь Монгол Улс буцааж авна гэдгээ хэлсэн. Бусад улс орнууд зарсан цөмийн түлшний хаягдлаа буцааж авахгүй гэдэг болохоор Арабын талаас мэдээж баяртай байгаа. Урьдчилсан байдлаар Монгол Улс 2020 оноос эхлэн Арабын Нэгдсэн Эмират улсад цөмийн түлш нийлүүлье гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Харин цөмийн хаягдлыг 2040-2050 оны үед буцааж авна гэж Монголын Засгийн газраас ярьж байгаа гэсэн. Хэдийгээр хараахан тодорхой болоогүй ч ийм чиглэлийн яриа хэлцэл явагдаж байгаа юм билээ. Монгол Улс нэгэнт далайн боомтгүй учир ОХУ, БНХАУ-аар дамжиж хаягдлаа буцааж зөөх хэрэг зайлшгүй гарна. Монголын хоёр хөрш улс аюултай тээвэрлэлт гэж үзээд дургүйлхэж ч болзошгүй. Тийм үед тодорхой хэмжээний мөнгө, татвар төлөөд улс орноор нь дамжуулан зөөж болохыг үгүйсгэхгүй. Мэдээж Монгол, Арабын төдийгүй хөрш хоёр улс оронтой гэрээ хэлцэл хийж байж энэ асуудал нэг мөр шийдвэрлэгдэх байх аа.

**-Манай улс цөмийн түлш хий-хээр төлөвлөж байгаа энэ үетэй давхцан Монгол Улсын газар нутагт цөмийн хаягдал агуулах гэсэн АНУ-ын сонирхол илтэд харагдаж байна гэж тодорхойлж болох уу. Өөрөөр хэлбэл Монго-лыг ятгаж байна, тийм үү?**

-АНУ-ын талаас Монгол Улсыг Арабын орнуудтай гэрээ хэлцэл ярьж байгааг мэдэхийн дээдээр сайн мэдэж байгаа. Нэгэнт 2050 онд Арабаас цөмийн хаягдлаа буцааж авах юм бол АНУ ч юмуу бусад улс орноос ирэх хаягдлыг цугт нь авахгүй юм уу гэсэн байдлаар санал тавиад байгаа гэж ойлгогд-сон. Цөмийн хаягдлаа хэрхэх вэ, хааш нь далдлах вэ гэж санаа зовниж байгаа үед Монгол Улс тусалбал бид баярлаж талархах болно. Зөвхөн баярлалаа гэж хэлэх биш нэлээн их хэмжээний мөнгө өгнө. Монголын талаас байгууламж барьчихгүй юмуу гэсэн саналыг хэлэх байдлаар ярьж байна. Хэрэв нутагтаа цөмийн хаягдал агуулбал төдий хэмжээний мөнгө өгнө гэж бүр хэмжээг нь хүртэл хэлээд байгаагаас үзэхэд шууд сонир-хол байгаа нь мэдээж хэрэг.

**-Тэгвэл Монгол Улсын Засгийн газар өөрсдөө ямар байр суурь баримталж байгаа бол. Таныг сурвалжлага хийх явцад юу анзаарагдав?**

-Энэ асуудал өнгөрсөн жилийн есдүгээр сараас эхлэн яригдаж эхэлсэн. Одоогоор хараахан юу ч шийдэгдээгүй гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

**-Гурван улсын уулзалт яг хэдийд болсон байдаг юм бэ?**

-Вашингтонд энэ 2011 оны хоёрдугаар сарын 4-ний өдөр Монгол, Япон, АНУ гэсэн гурван улс цугларсан уулзалт болсон.

**-Монгол Улсын Засгийн газар, Гадаад харилцааны яамнаас ийм төрлийн яриа хэлцэл огт болоогүй гэж мэдэгдээд байгаа. Шууд хэлэхэд таны бичсэн мэдээ, сурвалжлагыг ташаа гэж үгүйсгэж байна. Та үүнд юу хэлэх вэ?**

-Би өөрийнхөө бичсэн мэдээлэлд итгэлтэй байна. Монголчууд төдийгүй бусад улс орны ихэнх иргэд атомын цахилгаан станцын тухайд мэдээлэл хомс байдаг. Миний хувьд энэ сэдвийн дагуу мэдээ, мэдээлэл бичдэг болохоор асуудлыг тодорхой хэмжээнд сайн мэднэ. Би сүүлийн дөрвөн жилийн турш цөмийн түлшний талаар сурвалжлага хийж цөөнгүй улс оронд ажиллаж байна. Тэгээд ч Монгол,

АНУ, Японы гурван талт хэлэлцээрийн талаар зөвхөн ма-най “Майничи” сонин төдийгүй “Wall street journal”, “Reuters”, “Асахи” болон Японы телевиз, хэвлэлийнхэн бичиж, ярьж байна шүү дээ.

**-Таны ажилладаг “Майничи” сонинд гарсан мэдээллийг илтэд үгүйсгээд байгаа хандлага гарсаар байна. Ер нь сэтгүүлчдийн бичсэн бодит мэдээллийг илтэд үгүйсгэх хандлага бишгүй гардаг шүү дээ?**

-Тийм ээ. Энэ бол бидний мэргэжлийн хувьд гардаг байдаг л зүйлийн нэг. Монгол Улсын Засгийн газраас энэхүү мэдээллийг үгүйсгээд байгаа ч Японы Засгийн газраас гурван улсын хэлэлцээр болсон гэдгийг албан бус байдлаар хүлээн зөвшөөрч байна гэдгээ дурдаж байгаа. АНУ-аас гарч байгаа мэдээлэлд ч гурван улсын хэлэлцээрийг хүлээн зөвшөөрдөг. Хэрвээ миний бичсэн мэдээлэл ташаа байсан бол Японы өөр бусад олон хэвлэлээр дамжин мэдээлэгдэхгүй байх байсан биз дээ.